



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн халамжийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/144/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.bulgan@audit.mn

Булган аймаг
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Менежментийн захидал.....	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Төрийн аудитын санал, дүгнэлт

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР		ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.БАТЖАРГАЛ ТАНАА
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580		
2021.02.16	№ 57	
танай	-ны №	Г
Аудитын гэрчилгээ		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын төсвийн халамжийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p> <p>Зөрчилгүй санал дүгнэлт</p> <p>Улсын төсвийн халамжийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p> <p>Санал дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p> <p>Аудитаар Улсын төсвийн халамжийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p> <p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>		
006020106		

Үүрэг, хариуцлага

Улсын төсвийн халамжийн сан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,057,167.55</u>	<u>585,303.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,057,167.55	585,303.67
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,057,167.55	585,303.67
3121	Төгрөг	4,057,167.55	585,303.67
31213	Арилжааны банк дахь харилцах	4,057,167.55	585,303.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,057,167.55</u>	<u>585,303.67</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,350,930.00</u>	<u>2,763,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,350,930.00	2,763,000.00
413	Өглөг	6,350,930.00	2,763,000.00
4136	Бусад өглөг	6,350,930.00	2,763,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,715,400.00	1,504,480.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,635,530.00	1,258,520.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>(2,293,762.45)</u>	<u>(2,177,696.33)</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	(2,293,762.45)	(2,177,696.33)
512	Хуримтлагдсан үр дүн	(2,293,762.45)	(2,177,696.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,293,762.45)	(1,078,642.45)
51220	Тайлант үеийн үр дүн		(1,099,053.88)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,057,167.55</u>	<u>585,303.67</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	8,503,317,978.84	8,602,142,387.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,136,708.84	7,456,267.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,136,708.84	7,456,267.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	14,136,708.84	7,456,267.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,489,181,270.00	8,594,686,120.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,489,181,270.00	8,594,686,120.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,489,181,270.00	8,594,686,120.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,505,611,741.29	8,603,241,440.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,505,611,741.29	8,603,241,440.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,008,450.00	22,126,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,008,450.00	22,126,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,845,400.00	19,717,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,163,050.00	2,408,750.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,482,603,291.29	8,581,115,090.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,381,714,907.00	8,468,702,040.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,381,714,907.00	8,468,702,040.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,888,384.29	112,413,050.88
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,888,384.29	112,413,050.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,293,762.45)	(1,099,053.88)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,293,762.45)	(1,099,053.88)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,510,587,808.84	8,611,440,137.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,406,538.84	16,754,017.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,406,538.84	16,754,017.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	14,136,708.84	7,456,267.00
120009	Бусад орлого	7,269,830.00	9,297,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,489,181,270.00	8,594,686,120.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,489,181,270.00	8,594,686,120.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,489,181,270.00	8,594,686,120.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,506,530,641.29	8,614,912,000.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,506,530,641.29	8,614,912,000.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,723,050.00	19,363,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,723,050.00	19,363,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,560,000.00	16,954,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,163,050.00	2,408,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,483,807,591.29	8,595,548,650.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,382,746,864.47	8,483,135,600.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,382,746,864.47	8,483,135,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,060,726.82	112,413,050.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,060,726.82	112,413,050.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,057,167.55	(3,471,863.88)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,057,167.55	(3,471,863.88)

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,057,167.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,057,167.55	585,303.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	-2,293,762.45	-2,293,762.45
D01	2020 оны 06-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	-2,293,762.45	-2,293,762.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		1,215,120.00	1,215,120.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	-1,078,642.45	-1,078,642.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		-1,099,053.88	-1,099,053.88
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	-2,177,696.33	-2,177,696.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	8594686120.00	8488350790.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	8594686120.00	8488350790.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	8,594,686,120.00	8,488,350,790.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	8,594,686,120.00	8,488,350,790.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж				
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж			8,594,686,120.00	8,488,350,790.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,489,181,270.00	8,409,699,424.55	8,594,686,120.00	8,594,686,120.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,489,181,270.00	8,409,699,424.55	8,594,686,120.00	8,594,686,120.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,489,181,270.00	8,409,699,424.55	8,594,686,120.00	8,594,686,120.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын төсвийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Н.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, үндсэн хөрөнгө олж авах, цалингийн тооцооллыг үнэн зөв хийх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж гүйцэтгэв.

Улсын төсвийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 01/48 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэхэд бидний эрхэм зорилго оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль Засгийн газрын тогтоол
- 2019 оны 5 дугаар тогтоол “Журам батлах тухай”
- 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” 2019 оны 24, 25 дугаар тогтоолууд
- 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- 2019 оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай”
- 2019 оны 276 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2.5.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа бодлогын баримт бичиг

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улсын төсвийн халамжийн сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын төсвийн халамжийн санд 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Улсын төсвийн халамжийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 8603241.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 172064.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4057.1	585.3	-3471.8
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө			
Өр төлбөр	6350.9	2763.0	-3587.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4057.1	585.3	-3471.8

Тус газар нь өмнөх оны авлага өглөгийн үлдэгдэлгүй тухай онд авлага үүсгээгүй ажилласан байна.

Тайлант хугацаанд 2763.0 өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Урт хугацааны өр төлбөр үүсгээгүй байна.

Нийт зардал өмнөх оноос 98824.4 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт, амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалтын зардлуудаас шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 1215.1 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт нь тус сангийн өглөг 12 сараас дээш хугацаа өнгөрсөн тул журмын дагуу тушаалаар хассанаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11473583.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 11473583.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2878897.5 мянган төгрөгөөр бууруулж 8594686.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8594686.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 8594686.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Оны эхний үлдэгдэл 4057.1 мянган төгрөг, гүйцэтгэлээр улсын төсвөөс 8594686.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 8488350.7 мянган төгрөгийг зарцуулж 112413.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн, банк дахь үлдэгдэл 585.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8488350.7 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь хорио цээртэй холбогдуулан ХБИ-н амралт, рашаан сувиллын зардал, мөн 9 дүгээр сараас цахим халамж олгодог болсноос 112413.0 мянган төгрөгөөр /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 112413.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Хорио цээртэй холбогдуулан ХБИ-н амралт, рашаан сувиллын зардал, мөн 9 дүгээр сараас цахим халамж олгодог болсноос хэмнэлт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус сан нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх Төсөв/гүйцэтгэлийн чиглэлийн 52 мэдээлэл, Хөрөнгө оруулалт, тендер,

худалдан авалтын 39 мэдээлэл, Бусад 5 төрлийн 58 мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа хоцроосон байхгүй, мэдээлэх хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны хэрэгжүүлэлт 99 хувьтай хэрэгжсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6371.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-				
Албан шаардлага	-		-				
Зөвлөмж	2	6371.3	2	6371.3			
Нийт дүн	2	0	2	0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчил байхгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн асуудал байхгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2020/106/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:			Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1					
	ДҮН				